



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/461

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлийг сайжруулах, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор сангийн сайдаас ирүүлсэн чиглэлийн дагуу Монгол Улсын 2023 оны төсөвт үнийн өсөлтийн нэмэгдэл санхүүжилт нь батлагдсан төсөл арга хэмжээний хэрэгжилттэй холбогдуулан үнийн өсөлтийн нэмэгдэл санхүүжилт бүхий төсөл арга хэмжээнүүдийн гэрээг байгуулах, гүйцэтгэлээр санхүүжилтийг олгох асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

М.Хуягбаатар

Аймгийн засаг даргын орлогч)

Гишүүд:

Б.Оюунтуяа

(Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Г.Базар

(Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Х.Цэнд-Аюуш

(Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Б.Болд

(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагааны албаны дарга)

Д.Батчулуун

(Хөвсгөл Барилга Захиалагчийн Хяналтын Төв ААТҮГазрын дарга)

Нарийн бичгийн дарга:

Б.Энхжаргал

(Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

2. Ажлын хэсгээс гарсан шийдвэрийн явц, үр дүнг тухай бүр танилцуулж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

6711011785